



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1/289

Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах тухай**


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан журмын дагуу үйл ажиллагаа зохион байгуулах байнгын зөвлөл томилохыг Тэргүүн дэд дарга /Б.Алтанцом/, Гадаадад мэргэжилтэн бэлтгэх дунд хугацааны төлөвлөгөөг батлуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Т.Батжаргал/, журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг, жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны А/658 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын  
20.19 оны 04 дүгээр сарын 25 өдрийн  
1/229 дугаар тушаалын хавсралт



## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЧИГЛЭЛЭЭР СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж, сургалтын байгууллагад Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид ИНЕГ гэх/-ын захиалгаар иргэний нисэхийн ерөнхий газар /түүний харьяа алба, салбар/-ын ажилтан болон оюутныг суралцуулахад энэхүү журмыг баримтална.

1.2 Суралцагчдыг суралцуулах эрх зүйн үндэс нь Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичиг, “Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг болно.

1.3 ИНЕГ-ын гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан сургалтыг энэ журмаар зохицуулахгүй.

### ХОЁР. ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ

2.1 Иргэний нисэхийн салбарт шаардлагатай хүний нөөцийн судалгаанд тулгуурлан гадаадад мэргэжилтэн бэлтгэх дунд хугацааны төлөвлөгөөг захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж боловсруулан, жил бүр шинэчлэн батлуулна. Төлөвлөгөөнд нэн шаардлагатай тулгамдсан мэргэжил, суралцах хүний тоо, төсөв зэргийг багтаасан байна.

2.2 Тухайн жилийн сургалтад зарцуулагдах зардлын хэмжээг санхүү хариуцсан нэгж төсөвлөн, ИНЕГ-ын тухайн жилийн төсөвт тусган батлуулна.

2.3 Иргэний нисэхийн мэргэжлээр агаарын тээвэрлэгч байгууллагын захиалгаар суралцуулах тохиолдолд сургалтын гурван талт гэрээнд ИНЕГ болон тухайн агаарын тээвэрлэгч байгууллагатай сургалтын зардлыг харилцан тохиролцон шийдвэрлэнэ. Захиалагч байгууллага нь нийт сургалтын зардлын 20 /хорь/ хувиас доошгүй хувийг хариуцна.

### ГУРАВ. СУРГАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 ИНЕГ-ын даргын тушаалаар Сургалтын асуудал хариуцсан байнгын зөвлөл /цаашид САХБЗ гэх/-ийг томилно.

3.2 САХБЗ-ийн нарийн бичгийн дарга нь суралцахыг хүссэн өргөдөл гаргагчийн материалыг энэхүү журмын 5 болон 6 дугаар бүлгийн дагуу материалын



бүрдэлт, шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг нягтлан судлаж, нэгтгэн зөвлөлд танилцуулна.

3.3 САХБЗ нь тухайн жилийн гадаадад мэргэжилтэн бэлтгэх дунд хугацааны төлөвлөгөөний дагуу шаардлага хангасан өргөдөл гаргагчийн материалыг дараах үзүүлэлтүүдээр эрэмблэн хэлэлцэж, шалгаруулна. Үүнд:

1. ИНЕГ-т хэрэгцээ шаардлагатай мэргэжил эсэх;
2. Сурлагын амжилт гаргасан эсэх;
3. Сургалтын төлбөрийн хэмжээ;
4. Суралцах хугацаа;
5. Ар гэрийн нөхцөл байдал.

3.4 САХБЗ нь шийдвэрлэхээр шалгарсан суралцагчийн сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг бүхэлд нь юмуу тодорхой хэсгийг санхүүжүүлэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.5 Иргэний нисэхийн салбарт хэрэгцээ шаардлагатай мэргэжлээр гадаад орны засгийн газрын эсвэл тухайн сургуулийн тэтгэлгээр зөвхөн сургалтын төлбөрөө шийдвэрлүүлэн амжилттай сурч байгаа, тус салбарт ажиллах хүсэлтэй оюутан болон ажилтны хүсэлтийг судалж, иргэний нисэхийн салбарт шаардлагатай мэргэжил гэж үзвэл зохих амьжиргааны зардлыг САХБЗ хэлэлцэж, шийдвэрлэнэ.

3.6 ИНЕГ-ын оюутан нь суралцаж байх хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээл завсардах, сургалтын гэрээний хугацааг сунгах шаардлагатай болсон тохиолдолд 3 сарын өмнө ИНЕГ-ын даргад өргөдөл гаргаж, өргөдлийг САХБЗ-өөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

3.7 Дотоодын их дээд сургуульд суралцаж байгаа цаашид ИНЕГ-т ажиллах сонирхолтой, сургуулийнхаа тэргүүний оюутан, олон улсын чанартай физик, математикийн олимпиадад амжилттай оролцож эхний 3 байрыг удаа дараа эзэлсэн, иргэний нисэхийн чиглэлээр гадаадын их дээд сургууль коллежид суралцах хүсэл эрмэлзэлтэй санхүүгийн чадамжгүй оюутны асуудлыг САХБЗ хэлэлцэн шийдвэрлэж болно.

3.8 Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж сургалтын гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хууль эрх зүйн нэгжтэй хамтран сургалтын гэрээг дүгнэнэ.

3.9 Суралцагч нь сургалтын гурван талт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол САХБЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийн дагуу гэрээг цуцалж, гарсан зардлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж хууль эрх зүйн нэгжтэй хамтран гүйцэтгэнэ.

3.10 САХБЗ нь улиралд нэг удаа гадаадад мэргэжилтэн бэлтгэх дунд хугацааны төлөвлөгөөнд батлагдсан тоо, төсвийн дагуу ирүүлсэн материалын хүрээнд хэлэлцэж, гарсан шийдвэрийг ИНЕГ-ын даргад танилцуулна.

3.11 ИНЕГ-ын даргаас гарсан шийдвэрийг албажуулан, биелэлтэд хяналт тавихыг захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж гүйцэтгэнэ.

## **ДӨРӨВ. СУРАЛЦУУЛАХ ХЭЛБЭР, ХУГАЦАА, ЧИГЛЭЛ**

4.1 Сургалт нь дараах хэлбэр, хугацаатай байна. Үүнд:

4.1.1 Иргэний нисэхийн салбарын хүний нөөц бэлтгэх мэргэжлийн сургалт:

- Бакалаврын зэргийн сургалт;
- Мэргэжлийн диплом.

4.1.2 Мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалт:

- Магистрын зэргийн сургалт;
- Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт (3 сараас дээш).

4.1.3 Энэхүү журмын 4.1.2-т заасан сургалтыг зайн сургалтад хамруулах хэлбэрээр зохион байгуулж болно.

4.2 Иргэний нисэхийн чиглэлээр мэргэжлийн хүний нөөцийг сургаж, бэлтгэхдээ дараах үндсэн мэргэжлүүдээр бэлтгэнэ. Үүнд:

4.2.1 Нислэгийн хөдөлгөөний удирдагч/удирдлага;

4.2.2 Агаарын тээврийн зохион байгуулалт, Агаарын тээврийн эдийн засагч, Нисэхийн менежмент;

4.2.3 Нисэх буудлын ашиглалт, барилга байгууламжийн төлөвлөлт;

4.2.4 Аэродром төлөвлөлт, ашиглалт;

4.2.5 Нисэхийн холбоо, навигацийн тоног төхөөрөмжийн ашиглалт;

4.2.6 Иргэний нисэхийн хууль, эрх зүй, олон улсын харилцаа;

4.2.7 Агаарын навигацийн менежмент;

4.2.8 Онгоц, газрын үйлчилгээний тусгай тоноглолын авто машин, механизмын оператор, инженер, техник.

4.3 Иргэний нисэхийн салбарт шаардлагатай дараах захиалгат мэргэжлүүдээр бэлтгэнэ. Үүнд:

4.3.1 Агаарын хөлгийн нисгэгч;

4.3.2 Агаарын хөлгийн засвар үйлчилгээ, ашиглалт, хэрэглэл цахилгааны инженер, техникч.

4.4 Суралцагчийн суралцах гадаадын их, дээд сургууль, коллеж, сургалтын байгууллага нь ИНЕГ-аас гэрчилгээжсэн эсвэл хамтран ажиллах гэрээтэй байна.



## **ТАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХАМРАГДАХ ХҮРЭЭ**

5.1 Энэхүү журамд заасан сургалтад дараах шаардлагыг хангасан ажилтан, оюутныг бүртгэнэ. Үүнд:

5.1.1 Журмын 4.1.1-т хамрагдах ИНЕГ, түүний харьяа алба болон агаарын тээврийн гэрчилгээ эзэмшигч агаарын тээвэрлэгч байгууллагын ажилтан нь тухайн байгууллагадаа мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан үндсэн ажилтан байх ба 21-30 хүртэлх насны Монгол Улсын иргэн байх;

5.1.2 Журмын 4.1.1-т хамрагдах оюутан нь гадаадын их, дээд сургууль, коллеж, сургалтын байгууллагад иргэний нисэхийн салбарт зайлшгүй хэрэгцээ шаардлагатай мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа 18-25 насны Монгол Улсын иргэн байх;

5.1.3 Журмын 4.1.2-т заасан магистрын сургалтад хамрагдах шаардлагатай мэргэжлийн чиглэл нь гадаадад мэргэжилтэн бэлтгэх дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан байна.

5.1.4 Журмын 4.1.2-т заасан магистрын сургалтад зөвхөн ИНЕГ, түүний харьяа албанд 5-аас доошгүй жил ажилласан үндсэн ажилтан хамрагдана.

5.1.5 Журмын 4.1.1, 4.1.2-т заасан магистрын сургалтад хамрагдах ажилтан нь ажиллаж байгаа ажил мэргэжлийн дагуу суралцана.

5.2 Энэхүү журамд хамаарах ажилтан нь одоо суралцах гэж байгаа дипломын болон боловсролын зэргээр өмнө нь байгууллагын зардлаар суралцаагүй байх.

## **ЗУРГАА. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

6.1 Журмын 5.1.1-т заасан ажилтан суралцахаар хүсэлт гаргасан тохиолдолд дараах баримт бичгүүдийг бүрдүүлж, ИНЕГ-т бүртгүүлнэ. Үүнд:

6.1.1 Тэтгэлэгт хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн ажилтны хувийн өргөдөл;

6.1.2 Төрийн албан хаагчийн анкет;

6.1.3 Гурван үеийн намтар;

6.1.4 Сургуулийн тодорхойлолт (хэрэв ажилтан ажиллаж байх хугацаандаа сургуульдаа элсэн орж, тэнцсэн тохиолдолд тэнцсэн тухай баримт бичиг);

6.1.5 Суралцуулахыг дэмжсэн байгууллагын тодорхойлолт;

6.1.6 Захиалгат мэргэжлээр суралцаж байгаа тохиолдолд тухайн агаарын тээвэрлэгч байгууллагын сургалтын нийт зардлын хорин хувиас доошгүй хувийг хариуцна гэсэн байгууллагын тодорхойлолт;

6.1.7 Боловсролын зэрэг эзэмшсэн тухай баримт бичиг, дүнгийн жагсаалтын дэлгэрэнгүй хуулбар;

6.1.8 Бусад (шаардлагатай тохиолдолд бүрдүүлэх нэмэлт материал)

6.2 Журмын 5.1.2-д заасан оюутан суралцахаар хүсэлт гаргасан тохиолдолд дараах баримт бичгүүдийг бүрдүүлж, ИНЕГ-т бүртгүүлнэ. Үүнд:

6.1.1 Тэтгэлэгт хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн оюутны хувийн өргөдөл;

6.1.2 Оюутны талаарх мэдээллийг агуулсан анкет;

6.1.3 Гурван үеийн намтар;

6.1.4 Тухайн сургуульд суралцаж буй сургуулийн тодорхойлолт;

6.1.5 Суралцсан хугацааны сурлагын дэлгэрэнгүй дүнгийн жагсаалт, амжилтыг тодорхойлох баримт бичиг;

6.1.6 Боловсролын зэрэг эзэмшсэн тухай боловсролын баримт бичиг, дүнгийн жагсаалтын дэлгэрэнгүй хуулбар;

6.1.7 Сургалтын төлбөр төлсөн баримт.

6.3 Журмын 5.1.3-д заасан ИНЕГ-ын ажилтан суралцахаар хүсэлт гаргасан тохиолдолд дараах баримт бичгүүдийг бүрдүүлж, ИНЕГ-т бүртгүүлнэ. Үүнд:

6.3.1 Тэтгэлэгт хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн ажилтны хувийн өргөдөл;

6.3.2 Төрийн албан хаагчийн анкет;

6.3.3 Гурван үеийн намтар;

6.3.4 Суралцуулахыг дэмжсэн байгууллагын тодорхойлолт;

6.3.5 Боловсролын зэрэг эзэмшсэн тухай баримт бичиг, дүнгийн жагсаалтын дэлгэрэнгүй хуулбар.

6.4 Энэхүү журмын 5.1-д заасан шаардлагыг хангаагүй, эсхүл бичиг баримтыг дутуу, хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон бол бүртгэхгүй буюу бүртгэлээс хасна.



## **ДОЛОО. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТ, ХОЛБОГДОХ БАРИМТ МАТЕРИАЛЫН ЗОХИЦУУЛАЛТ**

7.1 Суралцагчийн суралцах хугацааны хяналт, мэргэжлийн чиг баримжаа, сургуультай хамтран ажиллах үйл ажиллагааг захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хариуцна.

7.2 Сургалтын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр хяналт тавина. Үүнд:

7.2.1 Тухайн сургуулийн гадаад, дотоодын оюутан хариуцсан нэгжтэй холбоо тогтоож, тухайн оюутны талаарх шаардлагатай мэдээлэл авах тогтолцоог бүрдүүлнэ;

7.2.2 Суралцагчийн сургалтын дүн болон сургалтын явцыг улирал бүр гаргаж сургуулиас албан ёсны баталгаажуулалтыг авна.

7.3 Суралцагчтай суралцагчийн болон байгууллагын хүлээх үүрэг хариуцлагыг нь нарийвчлан тусгасан “Иргэний нисэхийн ерөнхий газрын зардлаар гадаадад суралцах суралцагчтай байгуулах сургалтын гэрээ”, “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ”-г тус тус захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хариуцан байгуулна. Иргэний нисэхийн ерөнхий газрын зардлаар гадаадад суралцах суралцагчтай байгуулах сургалтын гэрээний загварыг энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг хоёрдугаар хавсралтаар, Агаарын тээвэрлэгч байгууллагатай байгуулах гурван талт гэрээний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталгаажуулна.

7.4 Иргэний нисэхийн салбарт 10-аас дээш жил ажилласан ажилтан нь байгууллагын зардлаар зөвхөн эчнээгээр суралцах тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа шаардахгүй.

7.5 Барьцаалж буй үл хөдлөх эд хөрөнгө нь сургалтын гурван талт гэрээнд тусгасан сургалтын нийт зардлын үнийн дүнтэй дүйцэхүйц байх ба түүнтэй холбоотой бусад харилцааг барьцааны гэрээ болон холбогдох хуулиар зохицуулна.

7.6 Санхүү хариуцсан нэгж нь оюутны сургалтын төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавьж, төлбөрийг цаг тухай бүрд нь шилжүүлнэ.

### **НАЙМ. ДОТООДЫН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАЖ БУЙ ОЮУТАНД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ**

8.1 ИНЕГ-ын тэтгэлгийг дараах шаардлага хангасан оюутанд олгоно. Үүнд:

8.1.1 Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Механик тээврийн сургуульд сурдаг байх;

8.1.2 Нисэх техникийн механик, Авионик мэргэжлээр 2 дугаар дамжаа төгссөн байх;

8.1.3 Сурлагын голч дүн 3.4 болон түүнээс дээш байх;

8.1.4 Тодорхой сэдвийн хүрээнд улсын болон төсөл, эрдэм шинжилгээний ажил, судалгаанд оролцдог байх;

8.1.5 Зохион бүтээсэн багаж төхөөрөмж, эрдэм шинжилгээний илтгэл нь уралдаан тэмцээнд шалгарсан байх (хийсэн бүтээлийн үр дүн нь хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн буюу үйлдвэрлэл практикт шилжсэн, гэрчилгээ лиценз авсан бол онцгойлон үзэх үндэслэл болно);

8.1.6 Суралцаж буй мэргэжилдээ дур сонирхолтой, авьяас чадвартай оюутан болохыг тодорхойлсон сургуулийн тодорхойлолт.

8.2 ИНЕГ-аас дотоодын их сургуульд суралцаж буй оюутанд олгох тэтгэлэг нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

8.2.1 Нэг оюутны жилийн сургалтын төлбөр;

8.2.2 Амжилттай суралцаж буй 3 хүртэлх оюутанд жилийн хугацаанд сар бүр тэтгэлэг олгох.

8.3 Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн Механик тээврийн сургуулийн захирлын зөвлөлөөс ирүүлсэн тэтгэлэгт хамрагдах шаардлага хангасан оюутны материалыг хүлээн авч, САХБЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, ИНЕГ-ын даргад танилцуулна.

## **ЕС. БУСАД**

9.1 Энэхүү журмын хэрэгжилтийн явцад гарсан маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.2 ИНЕГ-ын захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж нь энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

9.3 Энэхүү журмаар зохицуулагдаагүй сургалтын асуудлыг ИНЕГ-ын даргын зөвлөлөөр хэлэлцэж, гарсан шийдвэрийг даргын тушаалаар албажуулна.

--- ооОоо ---



БАТЛАВ.  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА /нэр/

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗАРДЛААР  
ГАДААДАД СУРАЛЦАХ СУРАЛЦАГЧТАЙ БАЙГУУЛАХ  
СУРГАЛТЫН ГЭРЭЭ  
№ .../20...**

**Нэг. Ерөнхий зүйл.**

- 1.1. Нэг талаас Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ыг төлөөлж ..... дарга ..... овогтой ....., Нөгөө талаас ..... хотын ..... дүүрэг, .....-р хороо, ..... гудамж, .....-р байр ..... тоотод оршин суугч ..... регистрийн дугаартай ..... овогтой ..... нар бид, ..... регистрийн дугаартай ..... овгийн ..... овогтой .....-ыг ..... Улсын ..... их сургуульд “.....” мэргэжлээр ..... зэргийн сургалтад ... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн ... жил суралцах хугацаатайгаар, нийт ..... (.....) ам.долларын зардалтайгаар суралцуулахаар дараах нөхцөлүүдийг харилцан зөвшилцөж энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээ нь 4 хувь үйлдэгдэж, хоёр тал гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба гэрээний нөхцөлд заагдсан хугацааг дуустал буюу сургууль төгсөөд иргэний нисэхийн салбарын хэрэгцээ, шаардлагатай газарт томилогдон ажилласан 5-аас доошгүй жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 1.3. Хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаантай тохиолдолд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү гэрээний 1.1-д заасан нийт зардлыг өсгөхгүй байна.
- 1.4. Энэхүү гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлт нь гэрээний 2.1-д заасан гэрээний гол нөхцөл буюу мэргэжлийг солихгүй байна.

**Хоёр. Иргэний нисэхийн ерөнхий газрын эрх, үүрэг**

- 2.1. ИНЕГ нь ..... овогтой .....-ыг ..... Улсын ..... их сургуульд “.....” мэргэжлээр ..... зэргийн сургалтад ..... оны ..... дугаар сарын .....-ний өдрөөс эхлэн ..... жил суралцах хугацаатайгаар, сургалтын төлбөрийг сургуулиас ирүүлсэн нэхэмжлэхээр, байр, хоолны зардлыг сар тутам жишигт заасан тарифаар, тээврийн зардлыг жилд 1 удаа Монголын үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг зорчиж байгаа агаарын шугамд хоорондын тооцоогоор тооцож, энэхүү гэрээний 1.1-д заасан сургалтын нийт ..... (.....) ам.долларын зардлыг хариуцан сургана.
- 2.2. Суралцагчийн ирүүлсэн сургалтын талаарх сургуулийн тодорхойлолт болон төлбөрийн дэлгэрэнгүй нэхэмжлэхийг үндэслэн сургалтын төлбөрийг шилжүүлнэ.
- 2.3. Энэхүү сургалтын гурван талт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг суралцагчаас шаардах, биелүүлээгүй тохиолдолд холбогдох арга хэмжээг авч, гэрээг цуцлах эрхтэй байна.
- 2.4. ИНЕГ-ын сургалтын асуудал хариуцсан ажилтан нь суралцагчийн хувийн дугаарыг /login ID/ авч сурлагын дүн болон сургалтын төлбөртэй танилцах эрхтэй.



- 2.5. Суралцагч сургалтын хөтөлбөрийг дүүргэж, мэргэжлээ эзэмшин төгсмөгц боловсролын бичиг /диплом/-ийг ИНЕГ хүлээн авах бөгөөд суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусмагц түүнд хүлээлгэн өгнө.
- 2.6. Байгууллагын удирдлага солигдох нь энэхүү гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

### **Гурав. Суралцагчийн эрх, үүрэг**

- 3.1. Суралцагч нь суралцах хугацаандаа өөрийн оюун ухаан, хүчин чадлаа бүрэн дайчлан суралцаж, сургалтын үндсэн хөтөлбөр, кредитийг 100 хувь хангаж, энэхүү гэрээний 2.1-д зааснаас бусад бүх зардлыг өөрөө хариуцан суралцана.
- 3.2. Суралцагч нь ИНЕГ-аас авч буй сургалтын зардлын дэмжлэгийг суралцах хугацаандаа төрийн сангийн зээл, тусламжтай давхардуулахгүй байна.
- 3.3. Суралцагч нь тухайн оршин суугаа орны хууль тогтоомж, сургуулийн дотоод журам, оюутны байрны дэглэмийг нарийн чанд сахиж, сахилга батын ямар нэгэн зөрчил /архи уух, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл таслах, хичээлээс хоцрох, өөр хоорондоо болон бусадтай маргах, хэл ам, хэрүүл тэмцэл хийх, зодолдох, хулгай хийх, худал хэлэх, чөлөө, зөвшөөрөл авалгүйгээр гадагш гарах, өөр хот, муж, улс руу аялах, хувийн ашиг сонирхолтой холбоотой ажил хэрэг, бизнес эрхлэх/ гаргахгүй суралцана.
- 3.4. Сурч байгаа тухайн улс оронд дайн байлдаан, үймээн самуун, байгалийн гамшиг зэрэг давагдашгүй хүчин зүйл үүссэн, суралцагчийн гэр бүлийн гишүүн /өөрийн эцэг эх, эхнэр нөхөр буюу хүүхэд, төрсөн ах эгч, дүү/ нас барах зэрэг ар гэрийн гачигдал, эрүүл мэндээс бусад шалтгаанаар /тухайлбал бизнес эрхлэх, жирэмслэх, визийн журам зөрчин тухайн улс оронд үлдэх зэрэг/ хичээл завсардахыг хориглоно. Хэрэв дурдсан шалтгаанаар эх оронд нь дуудах тохиолдолд түүнтэй холбогдон гарах аливаа зардлыг суралцагч өөрөө хариуцах ба долоо хоногийн дотор ИНЕГ-т бичгээр мэдэгдэнэ. Хичээл завсардсан нөхцөлд хичээлийн хөтөлбөрийг 7 хоногоос дээш хугацаагаар тасрахгүй байхаар зохицуулна.
- 3.5. Өөрийн хариуцлагагүй, ур чадвараас шалтгаалан сургалтын програмыг бүрэн дүүргэж чадаагүйгээс үүдэн гарсан нэмэгдэл зардлыг суралцагч өөрөө хариуцан төлж барагдуулах ба сонгон суралцаж байгаа мэргэжлийг солихгүй.
- 3.6. Суралцах хугацаандаа сургууль, багш нараас өгсөн үүрэг даалгавар, мөн тухайн оронд суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, Консулын газар болон оюутны ахлагчаас өгөгдөж буй заавар, зөвлөгөөг хүлээн авч биелүүлж байна.
- 3.7. Суралцагч ИНЕГ-ын сургалтын асуудал хариуцсан ажилтанд өөрийн хувийн дугаарыг /login ID/ өгөх үүрэгтэй бөгөөд суралцагчийн сурлагын дүн нь сургалтын төлбөрийг шилжүүлэх нэг үндэслэл болно.
- 3.8. Суралцагч тухайн улсад зорчих виз авахтай холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцан төлж барагдуулна.
- 3.9. Сургууль төгсөөд тухайн эзэмшсэн мэргэжлээрээ томилогдсон ажлын байранд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, 5-аас доошгүй жил тасралтгүй ажиллана. Энэ заалтыг биелүүлээгүй нөхцөлд суралцсан хугацааны нийт зардлыг ИНЕГ-т буцаан төлж, байгууллагыг хохиролгүй болгоно.
- 3.10. Суралцагч сургалтын програмыг биелүүлж чадаагүй, хангалтгүй үнэлгээтэй суралцсанаас /GPA-3.2-аас багагүй байх/ болон өөрийн буруугаас, түүнчлэн энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй, хэв журмын зөрчил гаргах, хулгай хийх,



согтууруулах ундаа хэрэглэх, нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, бусдын эрх чөлөөнд халдаж гэмтэл учруулах болон бусад зөрчлүүдийн улмаас тухайн улсын хууль журмыг зөрчсөн болох нь тогтоогдож цаашид суралцах эрхгүй болсон нөхцөлд сургалттай холбогдон гарсан бүх зардал, мөн хугацаанд олгогдсон оюутны тэтгэлгийн хамт сургалтын гэрээ цуцлагдсанаас хойш 6 сарын дотор өөрөө болон суралцагчийн ар гэр хариуцан ИНЕГ-т төлж барагдуулна.

#### Дөрөв. Бусад зүйл.

- 4.1. Суралцагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ өөрөө биелүүлж чадахгүйд хүрвэл түүний батлан даагч ..... регистрийн дугаартай, ..... хот, ..... дүүрэг, .....-р хороо, ..... гудамж, .....-р байр ..... тоотод оршин суугч ..... овогтой ..... хариуцан гүйцэтгэнэ.
- 4.2. Энэ гэрээнд дурдсан болон түүнтэй холбогдсон бусад асуудлаар гарсан маргааныг хэлэлцээний журмаар шийдвэрлэх ба үр дүнд хүрээгүй тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.3. Энэхүү гэрээний дагуу суралцагчийг төлөөлөн гэрээ байгуулж буй этгээд нь төлөөлөх эрхтэй болохоо нотлох үүрэгтэй.
- 4.4. Энэхүү гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлж гэрээний 3.9 дэх хэсэг биелэгдсэний дараа дахин байгууллагын зардлаар суралцах эрхтэй.
- 4.5. Гэрээний хугацаанд сурч буй мэргэжлээ сольсон тохиолдолд байгууллагаас гарсан зардлыг суралцагч буцаан төлнө.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

##### ИНЕГ-ыг төлөөлж:

..... дарга  
..... овогтой .....  
.....  
/Гарын үсэг/

##### Суралцагч:

..... овогтой .....  
.....  
/Гарын үсэг/

Регистрийн дугаар: .....  
Хаяг: .....  
Гар утас: .....  
Email: .....

##### Батлан даагч:

Түүний .....  
..... овогтой .....  
.....  
/Гарын үсэг/  
Ажлын газрын хаяг: .....  
Регистрийн дугаар: .....  
Хаяг: .....  
Гар утас: .....  
Email: .....

## БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

20.... оны ... дугаар сарын ...-ны өдөр

№ .../20.....

Улаанбаатар хот

Иргэний хуулийн 156 дугаар зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн Нэг талаас захиалагчийг төлөөлж, Иргэний нисэхийн ерөнхий газрын ..... дарга ..... овогтой ..... /Барьцаалагч/, нөгөө талаас ..... хотын ..... дүүрэг, .....-р хороо, ..... гудамж, ..... байрны ..... тоотод оршин суугч ..... регистрийн дугаартай ..... овогтой ..... /Барьцаалуулагч/ бид харилцан тохиролцож, доорх нөхцөлтэйгөөр энэхүү гэрээг байгуулав.

1. Барьцаалуулагч ..... овогтой ....., Барьцаалагч ..... овогтой ..... нарын хооронд ..... регистрийн дугаартай, ..... хотын ..... дүүрэг, .....-р хороо, ..... гудамж, ..... байрны ..... тоотод оршин суугч ..... овгийн ..... овогтой .....-ыг ..... Улсын ..... сургуульд “.....” мэргэжлээр ..... зэргийн сургалтад 20..... оны .... дугаар сарын .....-ны өдрөөс эхлэн ..... жил суралцах хугацаатайгаар, нийт ..... (.....) ам.долларын төлбөртэйгээр суралцуулахаар 20..... оны ..... сарын .....-ны өдрийн байгуулсан ..... дугаартай сургалтын гэрээний барьцаанд ..... (.....) ам.доллартай тэнцэхүйц төгрөгийг үүрэг гүйцэтгэх үеийн Монгол банкны ханшаар тооцож үл хөдлөх хөрөнгийг барьцаалж байна.
2. Барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх, түүнийг тодорхойлох: Барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх хугацаа ..... жил, төгсөж ирээд ажиллах хугацааны ..... жил, нийт ..... жил байна.
3. Барьцааны зүйл: Сургалтын төлбөрийн барьцаанд дараах эд хөрөнгийг талуудын тохиролцсон үнэлгээгээр барьцаалсан болно.

№	Барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл	Тайлбар
1	Барьцаа хөрөнгийн нэр, зориулалт	.....
2	Өмчлөгчийн овог, нэр	.....овогтой .....
3	Байршил, хаяг, талбайн хэмжээ	..... дүүргийн .....-р хороо, ..... гудамж, ..... байр, ..... тоот хаягт байршилтай ..... м.кв талбайтай үл хөдлөх хөрөнгө /..... хүний өмч/
4	Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар	Дугаар: ..... Ү-.....
5	Эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр, огноо	.....
6	Барьцаалагчийн үнэлгээ	..... ам.доллартай тэнцэхүйц төгрөг /үүрэг гүйцэтгэх үеийн Монгол банкны ханшаар тооцно/
7	Барьцаалуулагчийн үнэлгээ	..... төгрөг
8	Харилцан тохиролцсон үнэлгээ	..... ам.доллартай тэнцэхүйц төгрөг /үүрэг гүйцэтгэх үеийн Монгол банкны ханшаар тооцно/
9	Чанар /Сайн, дунд, муу болох алиныг бичих/	.....
10	Барьцааны зүйлийг өөр этгээдэд барьцаалуулсан эсэх /лавлагааны дугаар, огноо/	.....
11	Барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх /түрээслэх, бусдын газар дээр	Үгүй



	барилга байгууламж барих эрх гэх мэт/	
12	Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх болон тухайн эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, хугацаа /барьцааны эрх, хөршийн эрх, бусдын газар дээр барилга байгууламж барих эрх, узуфрукт, сервитут, үл хөдлөх түрээслэх болон хууль заасан бусад эрх/	Үгүй

4. Барьцааны хөрөнгө хэнд хадгалагдах: Барьцаалагч, барьцаалуулагч /Доогуур нь зурах/
5. Барьцаалагч барьцааны хөрөнгийг ашиглаж болох эсэх ҮГҮЙ
6. Барьцаагаар хангагдах шаардлага, хэмжээ, түүнийг тодорхойлох: Энэ нь сургалтын гэрээгээр тодорхойлогдох бөгөөд сургалтад хамрагдахтай холбогдуулан байгууллагаас зарцуулсан нийт төлбөр, барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх шүүхийн зардал, барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал гэх мэт уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн төлбөр хураамж, төлбөрийн нийлбэрээр тодорхойлогдоно.
7. Барьцаалагчийн эрх нь барьцаалбараар гэрчлэгдэхгүй бөгөөд барьцааны шаардлагыг шүүхийн журмаар хангуулна.
8. Нэмэлт нөхцөл:

.....

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### БАРЬЦААЛАГЧ:

..... дарга  
..... овогтой .....

.....  
/Гарын үсэг/

##### БАРЬЦААЛУУЛАГЧ:

..... овогтой .....

.....  
/Гарын үсэг/

Регистрийн дугаар: .....

Утасны дугаар: .....

БАТЛАВ.  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА /нэр/

БАТЛАВ.  
“.....” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
/нэр/

### ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЧИГЛЭЛЭЭР ГАДААДАД СУРАЛЦУУЛАХ ГУРВАЛСАН ГЭРЭЭ

20\_ оны \_ дугаар  
сарын \_-ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

Нэг талаас: Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид “ИНЕГ” гэх)-ыг төлөөлж  
..... дарга ..... овогтой .....

Нөгөө талаас: Монгол Улсын иргэн (цаашид “Суралцагч” гэх) ..... регистрийн  
дугаартай, ..... (ургийн овог) ..... (эцэг, эхийн  
нэр)  
..... (өөрийн нэр);

Гуравдагч талаас: ..... улсын бүртгэлийн дугаартай, ..... регистрийн  
дугаартай, ..... (цаашид “Захиалагч” гэх)-ийг  
төлөөлж  
..... албан тушаалтай ..... (эцэг, эхийн  
нэр)  
..... (өөрийн нэр)

нар (цаашид хамтад нь “талууд” гэх) сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцож, энэхүү  
гурван талт гэрээ (цаашид “гэрээ” гэх)-г дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

#### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээгээр захиалагчийн өгсөн захиалгын дагуу ..... (ургийн овог)  
..... (эцэг, эхийн нэр) ..... (өөрийн нэр )-ыг .....  
улсын ..... хотын ..... сургуульд ..... мэргэжлээр  
..... сургалтад 20.. оны .. сарын ..-нээс эхлэн нийт .. жил суралцах  
хугацаатайгаар, сургалтын нийт ..... /...../ ам.долларын  
зардалтайгаар суралцуулахтай холбоотой нөхцөл журмыг Монгол Улсын Иргэний  
хууль болон Монгол Улсын Их хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан  
“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт  
бичиг, “Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” болон ИНЕГ-ын даргын  
..... оны А/..... дугаар тушаалаар батлагдсан “Иргэний нисэхийн чиглэлээр  
суралцах журмыг тус тус үндэслэн талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг  
тогтооно.
- 1.2. Энэхүү гэрээг 6 хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж нотариатаар гэрчлүүлснээр  
хүчин төгөлдөр болох ба гэрээний нөхцөлд заасан хугацааг дуустал буюу сургууль  
төгсөөд Захиалагч байгууллагын хэрэгцээ, шаардлагатай газарт томилогдон  
ажилласан 5-аас доошгүй жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 1.3. Хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаантай тохиолдолд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт  
оруулж болох бөгөөд энэхүү гэрээний 1.1-т заасан нийт зардлыг өсгөхгүй болно.
- 1.4. ИНЕГ, захиалагчийн удирдлага солигдох нь энэхүү гэрээг цуцлах үндэслэл болохгүй.



### **Хоёр. Иргэний нисэхийн ерөнхий газрын эрх, үүрэг**

- 2.1. ИНЕГ нь суралцагчийн сургалтын төлбөрийг сургуулиас ирүүлсэн нэхэмжлэхээр, байр, хоолны зардлыг сар тутам жишигт заасан тарифаар, тээврийн зардлыг жилд 1 удаа Монголын үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг зорчиж байгаа агаарын шугамд хоорондын ..... /...../ ам.долларын зардлыг хариуцан сургана.
- 2.2. Жил бүр суралцагчийн ирүүлсэн сургалтын талаарх сургуулийн тодорхойлолт болон төлбөрийн дэлгэрэнгүй нэхэмжлэхийг үндэслэн сургалтын төлбөрийг шилжүүлнэ.
- 2.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг суралцагчаас шаардах, биелүүлээгүй тохиолдолд холбогдох арга хэмжээг авч, гэрээг цуцлах, учирсан хохирлыг төлүүлэх эрхтэй.
- 2.4. ИНЕГ-ын сургалтын асуудал хариуцсан ажилтан нь суралцагчийн хувийн дугаарыг /login ID/ авч сурлагын дүн болон сургалтын төлбөртэй танилцах эрхтэй.
- 2.5. Суралцагч сургалтын хөтөлбөрийг дүүргэж, мэргэжлээ эзэмшин төгсмөгц боловсролын бичиг /диплом/-ийг ИНЕГ хүлээн авах бөгөөд суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусмагц түүнд хүлээлгэн өгнө.
- 2.6. Захиалагчийг энэ гэрээний 4.1, 4.2-т заасан үүргээ биелүүлэхийг шаардах, үүргээ биелүүлээгүй тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

### **Гурав. Суралцагчийн эрх, үүрэг**

- 3.1. Суралцагч нь суралцах хугацаандаа өөрийн оюун ухаан, хүчин чадлаа бүрэн дайчлан суралцаж, сургалтын үндсэн хөтөлбөр, кредитийг 100 хувь хангаж, энэхүү гэрээний 2.1-д зааснаас бусад бүх зардлыг өөрөө хариуцан суралцана.
- 3.2. Суралцагч нь ИНЕГ-аас авч буй сургалтын зардлын дэмжлэгийг суралцах хугацаандаа төрийн сангийн зээл, тусламжтай давхардуулахгүй байна.
- 3.3. Суралцагч нь тухайн оршин суугаа орны хууль тогтоомж, сургуулийн дотоод журам, оюутны байрны дэглэмийг нарийн чанд сахиж, сахилга батын ямар нэгэн зөрчил /согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэх, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл таслах, хичээлээс хоцрох, өөр хоорондоо болон бусадтай маргах, зодолдох, хулгай хийх, худал хэлэх, чөлөө, зөвшөөрөл авалгүйгээр гадагш гарах, хувийн ашиг сонирхолтой холбоотой ажил хэрэг, бизнес эрхлэх/ гаргахгүй суралцана.
- 3.4. Сурч байгаа тухайн улс оронд дайн байлдаан, үймээн самуун, байгалийн гамшиг зэрэг давагдашгүй хүчин зүйл үүсэн, эрүүл мэнд, суралцагчийн гэр бүлийн гишүүн /өөрийн эцэг эх, эхнэр нөхөр буюу хүүхэд, төрсөн ах эгч, дүү/ нас барах зэрэг ар гэрийн гачигдлаас бусад шалтгаанаар /тухайлбал бизнес эрхлэх, жирэмслэх, визийн журам зөрчин тухайн улс оронд үлдэх зэрэг/ хичээл завсардахыг хориглоно. Хэрэв дурдсан шалтгаанаар эх оронд нь дуудах тохиолдолд түүнтэй холбогдон гарах аливаа зардлыг суралцагч өөрөө хариуцах ба долоо хоногийн дотор ИНЕГ-т бичгээр мэдэгдэнэ. Хичээл завсардсан нөхцөлд хичээлийн хөтөлбөрийг 7 хоногоос дээш хугацаагаар тасрахгүй байхаар зохицуулна.
- 3.5. Өөрийн хариуцлагагүй, ур чадвараас шалтгаалан сургалтын програмыг бүрэн дүүргэж чадаагүйгээс үүдэн гарсан нэмэгдэл зардлыг суралцагч өөрөө хариуцан төлж барагдуулах ба сонгон суралцаж байгаа мэргэжлийг солихгүй.
- 3.6. Суралцах хугацаандаа сургууль, багш нараас өгсөн үүрэг даалгавар, мөн тухайн оронд суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, Консулын газар болон оюутны ахлагчаас өгөгдөж буй заавар, зөвлөгөөг хүлээн авч биелүүлж байна.



- 3.7. Суралцагч ИНЕГ-ын сургалтын асуудал хариуцсан ажилтанд өөрийн хувийн дугаарыг /login ID/ өгөх үүрэгтэй бөгөөд суралцагчийн сурлагын дүн нь сургалтын төлбөрийг шилжүүлэх нэг үндэслэл болно.
- 3.8. Суралцагч тухайн улсад зорчих виз авахтай холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцан төлж барагдуулна.
- 3.9. Сургууль төгсөөд тухайн эзэмшсэн мэргэжлээрээ томилогдсон ажлын байранд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, 5-аас доошгүй жил тасралтгүй ажиллана. Энэ заалтыг биелүүлээгүй болон суралцах хугацаандаа гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд суралцсан хугацааны нийт зардлыг ИНЕГ болон Захиалагч талд гаргасан зардлыг буцаан төлж, байгууллагыг хохиролгүй болгоно.
- 3.10. Суралцагч сургалтын програмыг биелүүлж чадаагүй, хангалтгүй үнэлгээтэй /GPA-3.2-аас багагүй байх/ болон өөрийн буруугаас, түүнчлэн энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй, хэв журмын зөрчил гаргах, хулгай хийх, согтууруулах ундаа хэрэглэх, нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, бусдын эрх чөлөөнд халдаж гэмтэл учруулах болон бусад зөрчлүүдийн улмаас цаашид суралцах эрхгүй болсон нөхцөлд сургалттай холбогдон гарсан бүх зардал, мөн хугацаанд олгогдсон оюутны тэтгэлгийн хамт суралцахаа зогсоосноос хойш 6 сарын дотор өөрөө болон суралцагчийн ар гэр хариуцан ИНЕГ-т төлж барагдуулна.
- 3.11. Захиалагчийг энэ гэрээний 4.1-т заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

#### **Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг**

- 4.1. Захиалагч нь суралцаж төгссөн суралцагчийг эзэмшсэн мэргэжлийн дагуу зохих ажлын байраар 5-аас доошгүй жилийн хугацаатайгаар тогтвор суурьшилтай ажиллуулна.
- 4.2. Суралцагчтай холбоотой асуудлаар ИНЕГ-ын баталсан, дүрэм журмыг мөрдөх, тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 4.3. Үйлдвэрлэлийн дадлага хийхээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан бол дадлага хийх газрыг Захиалагч өөрөө олж зардлыг хариуцна.
- 4.4. Гэрээний хэрэгжилт, суралцагчийн суралцах явцтай танилцах, хяналт тавих эрхтэй.
- 4.5. Энэхүү гэрээний үүргээ биелүүлээгүйгээс гэрээ цуцлагдсан, сургуулиас хасагдсан, амжилтгүй төгссөн бол ажлын байраар хангах үүрэг хүлээхгүй.
- 4.6. Захиалагч нь энэхүү гэрээний 4.1, 4.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ИНЕГ-аас гарсан зардлыг ИНЕГ-т бүрэн төлж барагдуулна.
- 4.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг талуудаас шаардах, гэрээнд өөрчлөлт оруулах тухай санал гаргах эрхтэй.
- 4.8. Суралцагчийн нийт зардлын хорин хувиас доошгүй хувийг хариуцан суралцуулна.

#### **Тав. Бусад зүйл.**

- 5.1. Суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд ИНЕГ-т учирсан хохирлыг барагдуулах үүргийг өөрөө биелүүлж чадахгүйд хүрвэл түүний батлан даагч хариуцан гүйцэтгэнэ.
- 5.2. Энэ гэрээнд дурдсан болон түүнтэй холбогдсон бусад асуудлаар гарсан маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх ба үр дүнд хүрээгүй тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.



**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:**

**ИНЕГ-ыг төлөөлж:**

..... дарга  
..... овогтой .....

.....  
/Гарын үсэг/

**Захиалагчийг төлөөлж:**

..... дарга  
..... овогтой .....

.....  
/Гарын үсэг/

**Суралцагч:**

..... овогтой .....

.....  
/Гарын үсэг/

Регистрийн дугаар: .....

Хаяг: .....

Гар утас: .....

Email: .....